



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/150

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.3 дахь заалт, 42 дугаар зүйлийн 42.1.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1."Берлин-2023" тусгай олимпын Дэлхийн зуны наадамд Монгол Улсаа төлөөлөн волейболын спортын төрлөөр оролцох тус аймгийн харьяат Мөнхбаатарын Жаргалтуяа, Лхагвасүрэнгийн Лхагвадовдон, Дугармаагийн Эмүжин нарын замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат) -т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиглахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР